



БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
АЖЛЫН АЛБАНЫ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2022 оны 12 сарын 14 өдөр

дугаар A/198

Улаанбаатар хот

Төлбөртэй үзүүлэх үйлчилгээний үнийн
тариф тогтоох тухай

Боловсролын тухай хуулийн 39.2, 39.14 дэх заалт, Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлийн дүрмийн 11.1.1, 11.1.2 дахь заалтуудыг үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлөөс үзүүлэх төлбөртэй үйлчилгээний төлбөрийг нэгдүгээр, төлбөртэй үйлчилгээний орлогыг зарцуулах журмыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Уг тушаалыг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж ажиллахыг хүний нөөц хөгжлийн асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Батдэлгэр), үйл ажиллагааны орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавьж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн (Д.Сүнжидмаа)-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудит, чанарын дотоод баталгаажуулалт хариуцсан шинжээч (Б.Соёлмаа)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ

Ж.АРИУНБОЛД



Боловсролын Магадлан Итгэмжлэх
 Үндэсний Зөвлөлийн Ажлын албаны
 захирлын 2022 оны 10 дугаар сарын
 14 - ний өдрийн 11:19 тушаалын нэгдүгээр
 хавсралт



ТӨЛБӨРТЭЙ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНİЙН ТАРИФ

1. Үндэсний мэдээллийн төвийн үйлчилгээ

| № | Үйлчилгээний төрөл | Төлбөрийн хэмжээ/USD// |
|---|----------------------------|-------------------------|
| 1 | Дүйцүүлэлтийн лавлагаа | 10\$ (гадны иргэн 15\$) |
| 2 | Баталгаажуулалтын лавлагаа | 10\$ (гадны иргэн 15\$) |

2. Магадлан итгэмжлэлийн бусад үйлчилгээ

| № | Үйлчилгээний төрөл | Төлбөрийн хэмжээ/төгрөг/ |
|---|------------------------------------|--|
| 1 | Лавлагаа, тодорхойлолт | 20.000.0 |
| 2 | Акталсан хөрөнгө борлуулсны орлого | Өмч хамгаалах комиссын тогтоосон үнэлгээгээр |
| 3 | Гэрчилгээ дахин олгох | 100.000.0 |
| 4 | Архивын лавлагаа | 10.000.0 |

Боловсролын Магадлан Итгэмжлэх
Үндэсний Зөвлөлийн Ажлын албаны
захирлын 2022 оны 12 дугаар сарын
14 - ний өдрийн ~~14~~ ^{ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ}
Зөвлөл ^{ГУШААЛЫН ХОЁРДУГААР}
Хавсралт ^{ИГААН-ГАТААР УЛТ ЦӨӨЛДӨРҮҮС}

ТӨЛБӨРТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГЫГ ЗАРЦУУЛАХ ЖУРАМ

1. Нийтлэг үндэслэл

Энэхүү журам нь Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл /цаашид “БМИҮЗ гэх”/-ийн магадлан итгэмжлэх үйл ажиллагаанаас бусад төлбөртэй үйлчилгээ үзүүлснээс бий болсон орлогыг зарцуулахтай холбоотой харилцааг зохицуулна.

2. Төлбөртэй үйлчилгээнээс олсон орлогын бүртгэл, зарцуулалт

2.1 БМИҮЗөвлөл нь төлбөртэй үйлчилгээний орлого, зарцуулалтыг төлөвлөж, жил бүрийн төсөвт тусгана.

2.2 Төлбөртэй үйлчилгээнээс олсон орлого нь БМИҮЗөвлөлийн өөрийн үйл ажиллагааны бусад орлогод бүртгэгдэнэ.

2.3 Төлбөртэй үйлчилгээнээс олсон орлогыг БМИҮЗөвлөлийн харилцах данс болон кассанд хурааж, цахим бүртгэлийн болон санхүүгийн программд бүртгэнэ.

2.4 БМИҮЗөвлөл нь иргэнд төлбөр төлсөн баримтыг олгох бөгөөд уг баримтад БМИҮЗөвлөлийн нэр, хувь хүний төлсөн төлбөрийн хэмжээ, огноог тэмдэглэсэн байна.

2.5 БМИҮЗөвлөл төлбөртэй үйлчилгээний орлогыг тухайн үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой гарч байгаа шууд зардал болон байгууллагын ажиллагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зарцуулна. Үйлчилгээ үзүүлэхэд гарах шууд зардалд дараах зардлууд хамаарна.

2.5.1 Үйлчилгээ үзүүлсэн ажилтны цалин

2.5.2 Бичиг хэргийн зардал

2.5.3 Дотоод үйл ажиллагааны зардал

3. Хяналт

3.1 Төлбөртэй үйлчилгээний орлого, зарлагын гүйцэтгэл болон төлбөрт үйлчилгээний хэрэгжилтийн байдалд БМИҮЗөвлөлийн дотоод аудит хариуцсан шинжээч улирал бүр хяналт хийж зөвлөмж гаргана.

3.2 Төлбөртэй үйлчилгээний талаарх иргэдийн өргөдөл, санал, хүсэлт гомдлыг шийдвэрлэсэн байдал, төлбөрт үйлчилгээний орлогын зарцуулалтын талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг БМИУЗөвлөлийн дарга хангаж ажиллана.



4. Хариуцлага

4.1 Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтан, ажилтанд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.